



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 298

Улаанбаатар хот

Г

Т

Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хяналтын “Миллениум Ай Ти” системийг нэвтрүүлж, шинэ горимд шилжсэнээс хойш хугацаанд Хорооны 2007 оны 156 дугаар тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх арилжааны гүйлгээний шимтгэлийн орлогын 10 хувь болох зохицуулалтын үйлчилгээний хөлсийн хэмжээг тооцож, тусгай зөвшөөрөл эзэмшигч компани тус бүрээр гаргаж, мэдээллийг сар бүрийн эхний 5 хоногт багтаан Хороонд мэдээлж ажиллахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандуулам/-д үүрэг болгосугай.

2. 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн шинээр данс нээсэн харилцагчийн шимтгэлийн хувь хэмжээг харилцагч тус бүрээр 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, мөн сарын 15-ны өдрийн дотор “ҮЦТТХТ” ХХК-д ирүүлэх, цаашид шинээр данс нээсэн харилцагчдын дээрх мэдээллийг “ҮЦТТХТ” ХХК-ийн Е-клиринг системд оруулах ажлыг тогтолжуулах, өөрийн компанийн үнэт цаасны арилжааны гүйлгээний шимтгэлийн орлогын 10 хувь болох зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Төрийн сан банк дахь Санхүүгийн зохицуулах хорооны 900025001 тоот дансанд сар бүрийн эхний 5 хоногт багтаан шилжүүлж байхыг нийт тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудад үүрэг болгосугай.

00/000

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН